



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 354

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын  
хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох,  
балансаас балансад шилжүүлэх  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Архивын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны ертгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 1 нэрийн 35,184,700.00 (гучин таван сая нэг зуун наян дөрвөн мянга долоон зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 10,555,410.00 (арван сая таван зуун тавин таван мянга дөрвөн зуун арван) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоож, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

*Д.Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ

000757

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2020 оны 3-р дүгээр сарын 8-ны өдрийн  
 35-дугаар тогтоолын хавсралт

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН  
 АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ  
 ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Тоо хэм жээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Цаашид ашиглах хугацаа (жилээр)
					Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	
1	Хьюндай соната, 35-79 УНГ (арал kmheb41bbca337548)	2011/2012	1	35,184,700.00	1	10,555,410.00	10,555,410.00	3
	Нийт дүн			35,184,700.00 (гучин таван сая нэг зуун наян дөрвөн мянга долоон зуун)		10,555,410.00 (арван сая таван зуун тавин таван мянга дөрвөн зуун арван)		